

ГАЗАР ЭЗЭМШИХ, АШИГЛАХ ЭРХИЙН ГЭРЧИЛГЭЭНИЙ ДУУДЛАГА ХУДАЛДААНЫ ЗАР

Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын Засаг даргын 2024 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн А/156 дугаар захирамжийг үндэслэн дор дурдсан байршилд газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээний нээлттэй дуудлага худалдааг цахим хэлбэрээр /интернетээр/ зохион байгуулахаар зарлаж байна.

1. Дуудлага худалдааны хэлбэр: Цахим хэлбэрээр /Интернетээр/ Засгийн газрын 2016 оны 10 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага худалдаа явуулах журам"-ын дагуу дараах 6 байршилд газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээний нээлттэй дуудлага худалдаа явагдана.

- I. Сүмбэр сум 4-р баг, Мөнх Хар хоолойд 17 га /170000м²/ газрыг худалдаа, нийтийн үйлчилгээний газар, төв, цогцолборын зориулалтаар
- II. Сүмбэр сум 4-р баг, Мөнх Хар хоолойд 4 га /40000м²/ газрыг үйлдвэрлэлийн барилга, байгууламж, бусад газрын зориулалтаар
- III. Сүмбэр сум 4-р баг, Мөнх Цагаан толгойд 0,5 га /5000м²/ газрыг ХАА-н үйлдвэрлэлийн цогцолбор газрын зориулалтаар
- IV. Сүмбэр сум 4-р баг, Мөнх Цагаан толгойд 0,5 га /5000м²/ газрыг ХАА-н үйлдвэрлэлийн цогцолбор газрын зориулалтаар
- V. Сүмбэр сум 6-р баг, Малх Сумт Улаан толгойд 0,06 га /625м²/ газрыг холбоо, мэдээлэл дамжуулах, хүлээн авах станцын зориулалтаар
- VI. Сүмбэр сум 5-р баг, Уулзвар Бага Сансар ууланд 0,06 га /625м²/ газрыг холбоо, мэдээлэл дамжуулах, хүлээн авах станцын зориулалтаар тус тус зарлаж байна.

2. Эзэмшүүлэх хугацаа: 15 жил /арван таван/ I, II, III, IV-р байршил

3. Ашиглуулах хугацаа: 5 жил /таван/ V, VI-р байршил

- 4. Анхны үнэ:** 1-р байршил 255000000 /Хоёр зуун тавин таван сая/ төгрөг
2-р байршил 120000000 /Нэг зуун хорин сая/ төгрөг
3-р байршил 4500000 /Дөрвөн сая таван зуун мянга/ төгрөг
4-р байршил 4500000 /Дөрвөн сая таван зуун мянга/ төгрөг
5-р байршил 937500 /Есөн зуун гучин долоон мянга таван зуун/ төгрөг
6-р байршил 937500 /Есөн зуун гучин долоон мянга таван зуун/ төгрөг

5. Дэнчин: 1-р байршил 255000000 /Хорин таван сая таван зуун мянган/ төгрөг

2-р байршил 120000000 /Арван хоёр сая/ төгрөг

3-р байршил 450000 /Дөрвөн зуун тавин мянган/ төгрөг

4-р байршил 450000 /Дөрвөн зуун тавин мянган/ төгрөг

5-р байршил 93750 /Ерэн гурван мянга долоон зуун тавин/ төгрөг

6-р байршил 93750 /Ерэн гурван мянга долоон зуун тавин/ төгрөгийг 100220008402 дансанд тушааж баримтыг хавсаргана.

6. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 39.1.6-д заасан хураамж буюу 12500 төгрөгийг 100220500941 дансанд тушаасан байх.

7. Гэрээний зүйл: Засгийн газрын 2024 оны 136 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтад заасны дагуу газар эзэмших, ашиглахтай холбогдсон зураг төслийг газар эзэмших, ашиглах гэрээ байгуулснаас хойш 6 сарын дотор багтаан боловсруулж ирүүлнэ.

8. Цахим хуудас: Газрын цахим биржийн www.mle.mn хаягаар нэвтэрч оролцоно.

9. Дуудлага худалдаанд оролцогчдыг бүртгэх хугацаа: Дуудлага худалдаанд оролцогчдыг 2024 оны 07 дугаар сарын 29-ний өдрийн 08 цаг 30 минутаас эхлэн 2024 оны 08 дугаар сарын 02-ны өдрийн 15 цаг 00 минут хүртэл зөвхөн ажлын цагаар бүртгэж, баталгаажуулна.


10. Дуудлага худалдаа эхлэх: Газрын цахим биржийн www.mle.mn хаягаар 2024 оны 08 дугаар сарын 05-ны өдрийн 09:00 цагаас эхлэнэ.

11. Дуудлага худалдаа явагдах хугацаа: 2024 оны 08 дугаар сарын 05-ны өдрийн 09:00 цагаас эхлэн 15:00 цаг хүртэл тасралтгүй үргэлжилнэ.

12. Дуудлага худалдаанд ялагчийг тодруулах журам: Дуудлага худалдаанд хамгийн өндөр үнийн санал ирүүлсэн оролцогч ялагч болох бөгөөд ялагч нь дуудлага худалдаанд оролцох хүсэлтээ хугацаанд нь

ирүүлж, дэнчин болон улсын тэмдэгтийн хураамжийг төлсөн, өөрийн санхүүгийн байдал, төлбөрийн чадварын тухай мэдээллээ үнэн зөв гаргасан, дуудлага худалдааны дэг журмыг зөрчөөгүй байна.

13. Газрын байршил, хил хязгаарын зураг схем:



14. Техникийн нөхцлүүд: Цахилгаан болон мэргэжлийн байгууллагын дүгнэлт, техникийн нөхцлүүд авагдаагүй болно.

15. Дуудлага худалдаа явуулах газрын байршил, хил хязгаар, заагийг харуулсан зураг, схем болон бусад дэлгэрэнгүй мэдээллийг Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын Засаг даргын Тамгын газрын 104 тоотод өгч байна.

Жич: Дуудлага худалдаанд оролцогч нь Газрын цахим биржийн www.mle.mn сайтын талаар болон Засгийн газрын 2016 оны 10 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралттай танилцах.

Холбоо барих утас: 70543387, 80158111